



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 49 болон 50 дахь долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ


2020 оны 11-р сарын 26-аас 12-р сарын 11-ний байдлаар

Ковид-19 цар тахлын эдийн засаг, санхүүгийн зах зээлд нөлөөлж буй нөлөөллийн эсрэг улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 29 дэх дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Дэлхийн улс орнуудын эдийн засгийн гүйцэтгэлд үндэслэн ОУВС-гийн нэгтгэсэн тооцооллоор дэлхийн эдийн засаг 2020 оны 3-р улиралд 0.8 хувиар агшжээ¹. Үүнд хөгжингүй орнуудын эдийн засаг 3.3 хувиар агшсан бол эрчимтэй хөгжиж буй орнуудын эдийн засаг 1.5 хувиар өссөн байна (Зураг 1).

Зураг 1. Дэлхийн эдийн засгийн өсөлт



NOTE: The advanced economies (ex. U.S.) aggregate includes the Euro Area, Japan, the U.K., Canada, Australia, South Korea, Switzerland and Sweden. The emerging economies aggregate includes China, Brazil, Russia, India, Mexico, Indonesia, Turkey, Argentina, South Africa and Colombia. The world aggregate includes these countries, which make up approximately 80 percent of world GDP computed using purchasing power parity (PPP)-adjusted GDP weights.

SOURCES: National Statistical Offices, International Monetary Fund, Haver Analytics

Globalization Institute
Federal Reserve Bank of Dallas

- Азийн хөгжлийн банкнаас 12-р сарын 10-нд Ази, Номхон далайн бүсийн² эдийн засаг 2020 онд 0.4 хувиар агших төсөөллийг зарлалаа. Ийнхүү төсөөлөл 9-р сарын төсөөллөөс 0.3 нэгж хувиар сайжрахад БНХАУ, Тайван, Энэтхэгийн эдийн засгууд төсөөллөөс хурдан сэргэж байгаа нь эерэгээр нөлөөлжээ. Ирэх онд бүсийн эдийн засгийн өсөлт 6.8 хувь

¹ Дэлхийн эдийн засаг 2020 оны 2-р улиралд 5.4 хувиар агшсан. Үүнд хөгжингүй орнуудын эдийн засаг 11.9 хувиар, эрчимтэй хөгжиж буй

болж сэргэх боловч үйлдвэрлэл цар тахлын өмнөх үеийн түвшинд хүрэхээргүй байна. АХБ-наас Хятадын эдийн засаг энэ онд 2.1 хувиар, ирэх онд 7.7 хувиар өсөхөөр төсөөлж байна.

- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас 2020 оны 12-р тайландаа дэлхийн эдийн засаг 2020 онд 4.2 хувиар агшиж, 2021 онд 4.2 хувиар, 2022 онд 3.7 хувиар өсөхөөр төсөөлжээ. Энэ нь өмнөх улирлын төсөөлөлтэй харьцуулахад 2020 онд 0.3 нэгж хувиар сайжирсан, 2021 онд 0.8 нэгж хувиар муудсан төсөөлөл юм. Энэ оны 3-р улирлаас хөл хорио суларч, үйлдвэрлэл, өрхийн хэрэглээ сэргэсэн ч цар тахлын хоёр дахь давалгааны улмаас Евро бүсийн эдийн засаг 4-р улиралд агших төлөвтэй байна. Харин улс орнуудад эдийн засгийн сэргэлт харилцан адилгүй байгаагийн зэрэгцээ ажил эрхлэлт хурдтай сэргэхээргүй, хөрөнгө оруулалтын тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа тул ирэх онд дэлхийн эдийн засгийн сэргэлт өмнөх төсөөллөөс

орнуудын эдийн засаг 0.5 хувиар тус тус агшсан байна.

² АХБ-ны гишүүн орнууд болох Ази, Номхон далайн 46 орны эдийн засаг багтана.



алгуур байх төлөвтэй гэж тус байгууллага үзэж байна.

- **“ОХУ-ын эдийн засаг бусад аж үйлдвэржсэн орнуудтай харьцуулахад хурдацтай сэргэлээ”** гэж тус улсын Сангийн дэд сайд Владимир Колычев мэдэгдлээ. Хэдийгээр ОХУ-ын цар тахлын эсрэг хэрэгжүүлсэн багц арга хэмжээний төсөв ДНБ-ий 4 хувьтай тэнцүү, Герман, Итали, АНУ зэрэг орнуудын аравны нэгээс ч бага байсан боловч хаврын улиралд өмнөх оны мөн үеэс 8 хувиар агшаад байсан эдийн засаг III улиралд 3.6 хувиар агшив. Энэ нь G-20-ийн улс орнууд дунд эхний тавд орох үзүүлэлт болов. Хямралын эсрэг багц арга хэмжээний төсөв бага байсан хэдий ч энэ оны төсвийн зарцуулалт 27 хувиар өссөн нь бусад Европын орнуудаас өндөр байгааг В.Колычев онцоллоо. “ОХУ-ын эдийн засаг III улиралд хурдтай сэргэсэн нь II улиралд хохирол бага амссантай холбоотой. Учир нь ОХУ-ын цар тахлын хорио цээрийн дэглэм Европын бусад орнуудаас өөр” гэж тэрээр хэлжээ. Цар тахлын үеийн шууд дэмжлэгүүдийн нэг болох хүүхэдтэй өрхүүдэд олгосон тэтгэмжийн үр дүнд II улиралд 3-5 хувиар өссөн хэрэглээ үргэлжлэн 1-2 хувиар өссөөр байна. Мөн жижиг бизнесүүд болон нефть, химийн бүтээгдэхүүний салбаруудад татварын хэд хэдэн удаагийн хөнгөлөлт үзүүлсэн бөгөөд мэдээллийн технологийн салбарын татварыг 20-оос 3 хувь хүртэл бууруулсан байна.
- **Европын Төв банк** КОВИД-19 цар тахлаас болж хямраад байгаа эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд банкуудад илүү хямд санхүүжилт олгох зорилгоор **бонд худалдан авалтын хөтөлбөрөө уртасгаж, 500 тэрбум еврогоор өргөжүүлэхээр болов.** Ингэснээр нийт бонд худалдан авалтын

хөтөлбөрийн хэмжээ 1.35 их наяд еврогоос 1.85 их наяд еврод хүрч нэмэгдэхийн зэрэгцээ хөтөлбөрийн хугацааг 2021 оны 6-р сар хүртэл байсныг 2022 оны 3-р сар хүртэл хэрэгжүүлэхээр сунгасан байна. Европын Төв банкны тэргүүн Кристин Лагард хэлэхдээ “Евро бүсийн эдийн засаг 2020 оны IV улиралд 2.2 хувиар агшиж, ирэх жилийн эхэн үед эдийн засгийн уналт үргэлжлэх төлөвтэй, инфляцын түвшин бага хэвээр” байгааг онцолжээ. Мөн Европын Төв банк ирэх жилийн эдийн засгийн төсөөллийг 3.9 хувь болгож бууруулжээ. Гэсэн хэдий ч 2022 оны төсөөллөө 4.2 хувь болгон нэмэгдүүлж, 2023 онд 2.1 хувь байхаар тооцсон байна. Төв банк суурь хүүгээ хасах 0.5 хувьд хэвээр үлдээв.

- **АНУ-д 12-р сарын эхний 7 хоногт 947,000 ажилчин ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт шинээр гаргасан** талаар тус улсын Хөдөлмөрийн Яамнаас мэдэгдэв. Сүүлийн нэг сард ажилгүйдлийн тэтгэмж хүсэгчдийн тоо 3 дахин, 11-р сарын эхний долоо хоногоос хойш 250,000 хүнээр нэмэгджээ. Цар тахлын үед ажилгүйдлийн тэтгэмж, мужийн болон улсын тэтгэмж авах эрхгүй хүмүүс, бие даасан ажил эрхлэгчид болон бусад хүмүүсийг хамарсан холбооны хөтөлбөрүүдэд хамрагдах хүсэлтэй иргэдийн тоо мөн өмнөх долоо хоногоос огцом буюу ойролцоогоор 428,000-оор өсөөд байна.
- Их Британи болон Европын Холбооны худалдааны хэлэлцээрт талууд тохиролцоонд хүрэхгүй бол **Их Британид хүнсний бүтээгдэхүүний үнэ ирэх жилээс огцом нэмэгдэхээр байгааг** жижиглэнгийн худалдааны салбарынхан анхааруулж байна. Их Британийн Ерөнхий сайд Борис Жонсон 12-р сарын 10-нд “Их Британи хэлэлцээр байгуулахгүй байх өндөр магадлалтай”



гэж мэдэгдэв. Хэлэлцээр хийгээгүй тохиолдолд Их Британи Европын холбоотой Дэлхийн худалдааны байгууллагын нөхцөлөөр худалдаа хийх юм. Ингэснээр 2021 оны 1-р сарын 1-нээс эхлэн Европын холбооноос импортолж буй хүнсний бүтээгдэхүүний 85 хувьд нь 5 хувиас дээш хувийн татвар ногдож, хүнсний инфляц өсөхөөр байна. Дундаж тариф нь 20 хувиас дээш байх бөгөөд үүнд үхрийн мах 48 хувийн, өргөст хэмх 16 хувийн, шанцайны ургамал 10 хувийн гэх зэргээр тариф ногдохоор байна.

Эх сурвалж:

1. Financial Times, [ECB launches fresh stimulus to support Covid-hit eurozone economy](#)
2. Financial Times, [Russia's economy "recovered" quicker than most of industrialised world](#)
3. New York Times, [Unemployment Claims Jump, Casting New Shadow Over U.S.Economy](#)
4. Reuters, [UK retail industry warns of higher prices with no EU trade deal](#)
5. Federal Reserve Bank of Dallas, [Global economic conditions](#)
6. ADB, [Asian development outlook, December 2020](#)
7. Alibaba, [Coal price](#)

2

БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил 11-р сард үргэлжилж, цаашид хадгалагдах төлөвтэй байна. Үүнд:

- **Аж үйлдвэрлэлийн салбар дахь үйлдвэрлэл** 10-р сард өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өссөн бол 11-р сард хүлээлтээс өндрөөр 7.3 хувь хүрч нэмэгдэх төлөвтэй. Үүнд:
 - i. Дотоод эрэлт сэргэж байна – хөрөнгө оруулалтын эрэлтэд Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд дэмжлэг болж байна. Барилгын салбарын PMI индекс 11-р сард 60-аас дээш үзүүлэлттэй байсан нь тус салбарт тэлэлт үргэлжилснийг илэрхийлж байна. Мөн газрын тосны боловсруулах үйлдвэрлэл, үйлдвэрүүд дахь гангийн нөөц зэрэг өндөр давтамжтэй үзүүлэлтүүд цар тахлын өмнөх үеийн түвшнээс нэмэгдсэн зэрэг нь өсөлтөд нөлөөлөв.
 - ii. Гадаад эрэлт огцом нэмэгдсэн – худалдааны гол түнш орнуудын аж үйлдвэрлэлийн салбарын идэвхжил хадгалагдсан, Евро бүс, АНУ-ын PMI индексүүд 11 сард өссөн үзүүлэлттэй байв. Экспорт өмнөх оны мөн үеэс 21.1 хувиар өссөн нь 2018 оны 3-р сараас

хойшхи хамгийн өндөр өсөлт болов. Үүнд дэлхий нийтэд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, түүхий эдийн экспортын эрэлт нэмэгдсэн нь нөлөөлжээ. Машин механик, цахилгаан бараа, нэхмэл эдлэл, пластик бүтээгдэхүүний экспорт өссөн бол хувцас, цүнхний экспорт буурчээ.

iii. БНХАУ-ын нүүрсний импорт 11-р сард 11.7 сая тонн байсан нь өмнөх оны мөн үеэс 43.8 хувиар буурсан үзүүлэлт болов.

- **Жижиглэн худалдаа** 10-р сард өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өссөн бол 11-р сард 4.6 хувиар нэмэгдэх төлөвтэй.

Долоо хоногийн мэдээгээр үл хөдлөх хөрөнгийн салбарын борлуулалт, метро болон замын хөдөлгөөний систем дэх зорчигчдын тоо цар тахлын өмнөх үеийн түвшнээс нэмэгдсэн хэвээр байна. 11-р сарын 11-ний өдөр болсон “Ганц бие хүмүүсийн өдөр”-өөр цахим худалдан авалт эрс нэмэгдсэн, үйлчилгээний салбарын индекс 2012 оны 11-р сараас хойш хамгийн ихээр нэмэгджээ.



- **БНХАУ-ын зээл олголт 11-р сард өссөн** нь дотоод эдийн засгийн идэвхжлийг дэмжиж , M2 мөнгөний нийлүүлэлт өсөлттэй гарав. Үүнд:
 - Нийгмийн нийт санхүүжилт (social aggregate funding) 10-р сард өмнөх сараас 1.42 их наяд юаниар өссөн бол 11-р сард хүлээлтээс бага зэрэг өндрөөр 2.13 их наяд юаниар нэмэгдэв.
 - Шинээр олгосон зээлийн хэмжээ 10-р сард 690 тэрбум юань байсан бол 11-р сард 1.43 их наяд юань хүрч нэмэгджээ. Ийнхүү мөнгөний нийлүүлэлт 10-р сард өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар, 11-р сард 10.7 хувиар тус тус нэмэгдэв.
 - Бондоор дамжуулан корпорациудад олгосон зээл 10-р сард 252 тэрбум юань байсан бол 11-р сард 86.2 тэрбум

юань хүрч эрс буурав. Урт хугацаатай корпорацийн зээл 10-р сард нийт зээлийн 60 хувийг эзэлж байсан бол 11-р сард 41 хувьд хүрч буурчээ. Харин бизнесийн зээл олголт 10-р сард 233 тэрбум юань байсан бол 11-р сард 781 тэрбум юань хүрч нэмэгдлээ.

ББСБ зээлийн бүтээгдэхүүний дүн 10-р сард 214 тэрбум юаниар буурсан бол 11-р сард 204 тэрбум юаниар буурав. Харин шинээр олгосон өрхийн зээлийн хэмжээ 753 тэрбум юаниар нэмэгдсэн бол банк бус санхүүгийн байгууллагад олгосон зээлийн хэмжээ 104 тэрбум юаниар буурав.

Эх сурвалж:


1. *China React: Credit growth solid, but funding strains show, Bloomberg*
2. *China Preview: Activity-Recovery firing on all cylinders, Bloomberg*




МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

| Бодит гүйцэтгэл | | | | | | | Товч тайлбар |
|---------------------------|-------------------------------|----------|--------|---------|--------------|--------|--|
| | Үнэ (-1 day) 2020/12/10 | Өөрчлөлт | | | | YoY | |
| | | daily | weekly | monthly | year to date | | |
| Зэс | 7861 | 0.0% | 1.0% | 13.7% | 27.5% | 29.5% | Дэлхийн хэмжээнд КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдсэн хэдий ч “Pfizer” вакцины эхний шатны туршилт 90 хувийн үр дүнтэй гарсан нь зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж үнэ нэмэгдэхэд голлон нөлөөлөв. |
| Төмрийн хүдэр | 133.8 | 0.0% | 4.1% | 11.1% | 31.3% | 55.4% | БНХАУ энэ онд барилгын салбараа эрчимтэй дэмжсэний үр дүнд төмрийн хүдрийн эрэлт сайн байх төлөвтэй бөгөөд коксжих нүүрсний эрэлт өндөр байхаар байгаа нь үнэ нэмэгдэхэд голлон нөлөөлөв. |
| Алт | 1836.5 | 0.1% | 0.0% | -2.1% | 20.3% | 24.6% | Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал өндөр, хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт өндөр байна. Гэсэн хэдий ч “Pfizer” вакцины эхний шатны туршилт 90 хувийн үр дүнтэй байна гэсэн мэдээ зах зээл дэх тодорхой бус байдлыг бууруулж алтны үнэ хадгалагдахад нөлөөлөв. |
| Газрын тос (Брент) | 50.2 | 0.2% | 2.3 | 15.0% | -24.0% | -21.7% | КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдэж байгаатай зэрэгцээд газрын тосны үнэ буурч байна. Гэсэн хэдий ч “Pfizer” вакцины туршилт амжилттай болж буй мэдээ үнэ нэмэгдэхэд нөлөөлөв. Гэсэн хэдий ч олон улсын эрчим хүчний байгууллагын тооцооллоор дэлхийн газрын тосны эрэлт 2021 оны дунд хүртэл төдийлөн нэмэгдэхээргүй байна. |

Зураг 2. Дэлхийн зах зээл дээрх алт, төмрийн хүдрийн спот үнэ



Зураг 3. Дэлхийн зах зээл дээрх зэс, газрын тосны үнэ



Эх сурвалж: Блүүмберг